



## Ринчиннямьн АМАРЖАРГАЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүн

2008 онд УИХ-ын сонгуулийн 16-р тойрог Ховд аймгаас парламентад сонгогдсон. Монгол Улсын төсөв, мөнгөний бодлого, макро эдийн засаг, гадаад харилцаа, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, зэвсэгт хүчин, боловсрол, даяаршилал, чөлөөт худалдаа зэрэг асуудлуудыг төрийн бодлогын түвшинд түлхүү анхаарч ажилладаг.

- Төсвийн байнгын хорооны гишүүн
- Аюулгүй байдал, Гадаад бодлогын байнгын хорооны гишүүн
- Тусгай хяналтын дэд хорооны гишүүн
- Монгол-Их Британийн парламентын бүлгэмийн дарга
- Монгол-Люксембургийн парламентын бүлгэмийн дарга

<b>Утга:</b>	Ховд аймагт ажилласан тайлан
<b>Индекс:</b>	HVD/2010/01
<b>Хаана:</b>	Буянт, Ховд, (Улаанбуурай баг), Эрдэнэбүрэн, Мянгад, (Чацарганат баг), Чандмань, Жаргалант сумд
<b>Хэзээ:</b>	2010 оны 3 дугаар сарын 14-нөөс 18-ны өдрүүд
<b>Нэмэлт:</b>	

### ТОЙМ

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал 2010.03.14-18-ны өдрүүдэд өөрийн сонгогдсон тойрог Ховд аймгийн 6 сум, 2 багийн төвд ажиллалаа.

Нийт 480 гаруй сонгогчидод УИХ-ын гишүүний ажлын тайлан, УИХ-ын 2009 оны Намрын чуулганаар батласан бодлого шийдвэрийн талаар болон цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, санал бодлыг нь сонсож, 30 гаруй иргэдтэй ганцаарчилан уулзав.

Иргэд дараах нийтлэг асуултыг асууж, гишүүнээс хариулт авч, төр засгийн зүгээс баримталж буй бодлого, шийдвэрийн талаар мэдээлэл сонссон юм. **Үүнд:**

1. Өвөлжилт, зуд түүнээс үүдэн гарч буй нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар,
2. 2008 оны УИХ-ын сонгуулиар МАХН болон АН-ын мөрийн хөтөлбөрт тусгагдсан Эх орны хишиг, Эрдэнийн хувийн амлалт,
3. Төвөөс алслагдсан аймаг, орон нутагт ажиллаж, амьдарч буй хүмүүст бүсийн нэмэгдэл олгох,
4. Банкны зээлтэй малчид, төрийн албан хаагчид, тэтгэврийн настангуудын зээл, зээлийн хүүгийн төлөлтийн нөхцөл байдал,
5. Мал сүргийн бүтэц, тоо толгой тэдний байгаль дэлхий, бэлчээрийн даацад нөлөөлж буй байдал,
6. Төсөвт байгууллагын төсөв хүрэлцдэггүй байдал. Ялангуяа энэ жилийн өвөлжилт хүндэрч бензин шатахуун, халаалтын зардалд эхний хагас жилийн ногдсон төсвөө зарцуулсан **зэрэг** нийтлэг асуудлыг сумын удирдлага, иргэд, сонгогчид хөндсөн.

**Ажлын алба**  
Монгол Улс, Улаанбаатар хот  
Төрийн ордон – 211

Утас: 260127, Факс: 310127  
И-мэйл: [info@amarjargal.org](mailto:info@amarjargal.org)  
Цахи хуудас: [www.amarjargal.org](http://www.amarjargal.org)

## БУЯНТ СУМ – 2010.03.14

Буянт сумын удирдлага, төсөвт байгууллагын албан хаагчид УИХ-ын гишүүн Р.Амаржаргалтай уулзаж, сум, орон нутаг, төсөвт байгууллагын аж байдлын талаар танилцуулж, доорхи асуудалд дэмжлэг, туслалцаа хүссэн юм. Сумын хэмжээнд:

- 2021 он хүртэлх сум хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Газар нутгийн маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэхэд УИХ-аас тогтоол гаргуулах (Сайд нарын зөвлөл 1977 оны хилийн зааг тогтоох тухай 75 тогтоол),
- Үүнтэй уялдаж сумын иргэдэд газар өмчлүүлэхэд хүндрэлтэй байна,
- 1000 га-д усалгаатай газар тариалан эрхлэх зорилт тавин ажиллаж байна. Үүнд дэмжлэг үзүүлэх,
- Эмнэлэгийн машины норм дууссан тул олгож өгөх, 50 сая төгрөгний засвар хийх, жижиг Эхо аппараттай болгох тал дээр дэмжлэг үзүүлэх,
- Соёлын төвийг сандал, апартуртай болгож, номын сан байгуулахад дэмжлэг үзүүлэх,
- Сургуульд техник хэрэгсэл, компьютерийн хүрэлцээ муу тул үүнд дэмжлэг үзүүлэх
- Цэцэрлэгийн барилга 1982 онд баригдаж өдийг хүртэл засвар хийгдэж байгаагүй. Засвар хийхэд шаардлагатай 100-150 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, зэрэг асуудалд УИХ-ын гишүүн Р.Амаржаргалыг анхаарч ажиллан, дэмжлэг үзүүлэхийг хүссэн юм.



*Хөөрөг солилцож мэндлэх нь Монгол ёсон*



*Иргэд, сонгогчидтой хийсэн уулзалт*

### Иргэд, сонгогчидоос:

- Бүсийн нэмэгдэл олгох асуудал,
- МАХН болон АН-ын амласан “Эх орны хишиг”, “Эрдэнийн хувь” хүртээх тухай. Үүнтэй холбогдуулан – банкны зээлээс чөлөөлөх, амласан мөнгөө нэг мөр өгөх эсвэл өгч чадахгүй гэдгээ хэлж, огцрох хэрэгтэй гэсэн асуудал
- Малчдад тусламж үзүүлж буй асуудлыг эсэргүүцэж байна. Учир нь малын тоо толгой өсч, бэлчээрийн даац хэтэрч, байгаль орчинд сөргөөр нөлөөлж байна, нөгөө талаар малчид хариуцлагагүйн улмаас зудад нэрвэгдэж байна гэсэн хэсэг байхад малчид зудад нэрвэгдэж хамаг малаа алдаж байна, тиймээс төрөөс тусламж дэмжлэгээ нэмэгдүүлж, өвс тэжээлийг хүрэх ёстой эздэд нь өгөх, ил тод байх асуудал
- Жижиг, дунд үйлдвэрийн зээлийг оновчтой болгох, шалгуур өндөр тул хамрагдах боломж хомс байна,
- Шүдний эмчилгээ үнэгүй болох уу
- Засаг захиргаа, нутаг дэвсэр, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, орон нутагт эрх мэдэл шилжүүлэх асуудлыг боловсронгуй болгох,
- Өндөр настаны түлш, унааны зардалд өгдөг 140 мян.төг одоо 70 мян.төг болсон, мөн төрийн албан хаагчдын 36 сарын тэтгэмжийг 12 сар болгох,
- Төмс боловсруулах үйлдвэр чухал хэдий ч үр өгөөж, техник эдийн засгийн үндэслэлтэй судалгаа хийлгэж өгөх асуудлыг анхаарлдаа авна уу,
- Услалтын системийн асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэж өгөх,

зэрэг асуудлыг хөндөж, УИХ-ын гишүүн Р.Амаржаргал болон аймгийн ХЗБХ-ийн дарга Б.Алтанбадралт нараас мэдээлэл сонсож, санал солилцсон юм. Уулзалтад 90 гаруй иргэд оролцов.

**ТВ-ийн ярилцлага:** 19.30 минутаас аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг дөрвөн ТВ-д 1.30 минутын ярилцлага өгснөөс “Шинэ ертөнц” телевиз шууд дамжуулан Ховдын үзэгчдэд хүргэсэн юм. ТВ-ийн ярилцлагыг [www.youtube.com/ramarjargal](http://www.youtube.com/ramarjargal) хаягаар орж үзнэ үү.

### **ЖАРГАЛАНТ СУМ – 2010.03.15**



*Ховд аймгийн АН-ын хуралд  
үг хэлэв*

Ховд аймгийн АН-ын хуралдаан өглөөний 09.00 цагаас эхэлж:

- 2009 онд хийсэн ажлын тайлан, санхүүгийн тайлан,
- 2010 онд хийх ажлын төлөвлөгөө, орлого, зарлагын төлөвлөгөөг хэлэлцэж, гишүүд асуулт асууж, хариулт авав.
- АН-ын дотоод ротацийн сонгууль явагдаж, сумдын намын үүрээс аймгийн АН-ын хорооны гишүүнд сонгогдсон хүмүүсээ баталгаажуулж, улмаар Аймгийн намын хорооны гишүүдээс ҮЗХ-ны 9 гишүүн, Гүйцэтгэх зөвлөлийн 1 гишүүнийг дүрмийн дагуу сонгосон юм.

Аймгийн АН-ын хуралдаанд УИХ-ын гишүүн Р.Амаржаргал оролцож, үг хэлсэн юм.

## ХОВД СУМ – 2010.03.16



*Казак түмний үндэсний хувцас...*

Ховд сумын удирдлага, төсөвт байгууллагын албан хаагчид УИХ-ын гишүүн Р.Амаржаргалтай уулзав.

Сумын удирдлага: өвөлжилт хүндэрч 3000 гаруй толгой мал зүй бусаар хорогдсон, төр засаг, аймаг орон нутгаас зээл тусламж үзүүлж байгаа, иргэний бичиг баримтын зөрчлийг арилгах 1 сарын аян явагдаж байна, Науризын баярт бэлдэж байна, Тогтвортой амьжиргаа төсөлд бэлчээрийн менежментийн хүрээнд 1. тэжээл тарих, 2. худаг гаргах гэсэн хоёр чиглэлээр хүсэлт гаргасан, сарын бүрийн 25-ны өдөр багийн Засаг дарга нарын уулзалтаар мэдээ, тайлан, төлөвлөгөө хэлэлцдэг талаар мэдээлэл өгөв.

### Сумын хэмжээнд:

- ХХААХҮЯ-ны 7.0 тэрбум төгрөгний өртөг бүхий усжуулалтын системийн хүрээнд хамруулах хүсэлтэй байсан ч тархай бутархай, өртөг зардал өндөр байна гэсэн үндэслэлээр долоогийн тариалангийн талбай хасагдсан. Тэнд 150 тариачин байдаг,
  - Сумын төвөөс 5 км зайд гар аргаар алт олборлож, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Үйл ажиллагааг нь хориглоод дийлэхгүй байна,
  - Сургуулийн заалны асуудал хүндрэлтэй байна,
- зэрэг тулгамдсан асуудал байгаа талаар мэдээлэл хийлээ.



*иргэотэи хиисэн уулзалтын оараа...*

### Иргэд, сонгогчидоос:

- малчид зудад нэрвэгдэж хамаг малаа алдаж байна, хээл хаяж, төл авч чадахгүй байна,
- Залуучуудад ажлын байр олдохгүй, ажилгүйдлийн түвшин өндөр байна,

- Бэлчээрийн даац хэтэрсэн, жил ирэх тутам хадлан хураалт багасаж байна,
  - Аймгийн төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалт явуулдаг ч тэнцсэн хүнийг бус дарга нарын болон гадны хүнийг ажилд авч байна,
  - МАХН болон АН-ын амласан “Эх орны хишиг”, “Эрдэнийн хувь” ард иргэдэд хэрэгтэй байна. Ерөнхийлөгч хоёр намын амласан нийлбэр дүн 2.5 сая төгрөгийг ард иргэдэд өгүүлнэ гэсэн, хэзээ өгөх вэ?
  - Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрт оюутны тэтгэлэг олгох асуудлыг тусгасан байсан, энэ хэзээ хэрэгжих вэ?
  - Амлалт нэхэх ард түмний хөдөлгөөнийг юу гэж бодож байна?
  - Банкны зээлийн асуудал – 200 гаруй ахмадаас 166 нь тэтгэвэрийн зээлтэй байна, зээлийн хүүг чөлөөлөх, бууруулах, 2.5 сая төгрөгтөө суутгах хүсэлтэй байна,
- зэрэг асуудлыг хөндөж, УИХ-ын гишүүн Р.Амаржаргал болон аймгийн ХЗБХ-ийн дарга Б.Алтанбадралт нараас мэдээлэл сонсож, санал солилцсон юм. Уулзалтад 60 орчим иргэд оролцов.

Сумын төвд хийсэн уулзалтын дараа Улаанбуурай баг дээр 30 орчим иргэдтэй уулзалт хийв.

### *Ховд сум, Улаанбуурай баг дээр хийсэн уулзалтын дараа*



### **ЭРДЭНЭБҮРЭН СУМ – 2010.03.16**

Эрдэнэбүрэн сумын удирдлага, төсөвт байгууллагын албан хаагчид УИХ-ын гишүүн Р.Амаржаргалтай уулзаж, сум, орон нутаг, төсөвт байгууллагын аж байдлын талаар танилцуулж, доорхи асуудалд дэмжлэг, туслалцаа хүссэн юм. Сумын хэмжээнд:

- Өвөлжилт хүндрэлтэй байна,
- Шилжилт хөдөлгөөн их байна,
- Хадлангийн талбай багасаж, тэжээлийн ургамал, үр тариа хураалт жил ирэх тутам багасаж байна,
- Услалтын систем шийдэгдвэл хүнсний ногоо тариад байх боломжтой,
- Сургууль хоолны тогоо,
- Гэр цэцэрлэг ажиллуулахад тогны асуудал хүндрэлтэй байна, 1,2-р хоолны тоогоор хангахад туслалцаа үзүүлнэ үү,
- Эмнэлэг энэ жил ачаалал ихтэй ажилаж байна. Зудад нэрвэгдсэн малчид стресст их орж байна, H1N1 вирус манай суманд бүртгэгдсэн, ханиад томуу ихтэй байгаа учраас

дуудлага ихэссэн. Иймд илүү цагийн мөнгө олгох боломж хомосдсон, бензин шатахууны төсөвт зардал хэтэрсэн, эмнэлэгийн машины хугацаа дууссан, эмнэлэгийн ор хуучирсан, хоолны тогоо, Эхо аппарат хэрэгтэй байна. Эдгээр асуудалд дэмжлэг үзүүлж өгнө үү, зэрэг асуудалд УИХ-ын гишүүн Р.Амаржаргалыг анхаарч ажиллан, дэмжлэг үзүүлэхийг хүссэн юм.



*Эрдэнбүрэн суманд хийсэн уулзалтын үеэр – 2010.03.16*

Иргэд сонгогчидоос:

- Хоёр намын амласан “Эх орны хишиг” болон “Эрдэний хувь” болох 1.5 сая, 1.0 сая төгрөгийг хэзээ өгөх гэж байна,
- Бэлчээрийн даа хэтэрч, хадлангийн талбай багасаж байна. Үүний улмаас ган, зуд үргэлжилж байна. Суманд хиймэл нуур байдаг. Үүнийг усжуулахад жилд 5.0 сая орчим төгрөг зарцуулдаг, үүнд дэмжлэг үзүүлэх боломж, зэрэг асуудлыг хөндөж, УИХ-ын гишүүн Р.Амаржаргал болон аймгийн ХЗБХ-ийн дарга Б.Алтанбадралт нараас мэдээлэл сонсож, санал солилцсон юм. Уулзалтад 50 гаруй иргэд оролцов.

Эрдэнбүрэн сумд хийсэн уулзалтын дараа Мянгад сумын өвөлжилт хүндрэлтэй Чацарганат баг дээр 30 гаруй иргэдтэй уулзалт хийв. Уулзалт 3 цаг гаруй үргэлжилсэн.



### МЯНГАД СУМ – 2010.03.17

3 дугаар сарын 17-ны өглөө иргэдтэй уулзах байсан тул шөнө дунд хүрэлцсэн ирсэн даруйдаа сумын удирдлага, төсөвт байгууллагын дарга нарыг хүлээн авч уулзав.

#### Сумын хувьд:

- Өнгөрсөн жил Алтан хөхий уулын төрийн тахилга болсон. Энэ үеэр лус савдагаа баярлуулахаас илүүтэй хүрээлэн буй орчныг сүйтгэж өгдөг. Мөн суманд ямар ч эдийн засгийн ач холбогдол байдаггүй. Иймд 4 жил тутам дахидаг энэ хугацааг сунгаж өгөх, ядаж 8 жил болгох,
- Өвөлжилт хүндэрч ихэнхи нутгаар 0.2-1.0 метр зузаан цастай байна, малчдад хүрч очиход нормын бензин шатахуун хүрэлцдэггүй,
- Тусламжийн хүрээнд 15 тн тэжээл, 20 тн улаанбуудай, 100 уут гурил, цай ирсэн. Зудад хүнд нэрвэгдсэн айл, өрхүүдэд хуваарилсан,
- Эмнэлэгийн дуудлагын машины хугацаа дууссан, цус, шээсний шинжилгээний аппарат, 1, 2-р хоолны тогоо, бензин түлшний зардалд 4.0 сая төгрөгийн өр үүссэн,
- Сургуульд 28.0 сая төгрөгийн өртөг бүхий 350 ширээ, сандал хэрэгтэй байна,
- Соёл урлаг, спортын төвийн цогцолборын барилгын ажилд 750.0 сая төгрөг шаардлагатай байна. Үүнийг төсөвт тусгуулах тал дээр анхаарч ажиллана уу, зэрэг асуудалд УИХ-ын гишүүн Р.Амаржаргалыг анхаарч ажиллан, дэмжлэг үзүүлэхийг хүссэн юм.



*Мянгад суманд хурэлцэн ирсэн даруйдаа Сумын удирдлагатай уулзаж, тэдний санал бодлыг сонсов – 2010.03.16-ны өдрийн шөнө дунд*

Иргэд, сонгогчдоос:

- Төрөөс банкин дахь иргэдийн мөнгөн хадгаламжинд баталгаа гаргах, хадгаламж зээлийн хоршооны хохирогчдын хохиролыг барагдуулах гэх мэт арга хэмжээ авч байгаа нь татвар төлөгчдийн мөнгө шүү. Энэ мөнгийг үр ашигтай зүйлд зарцуулах байтал өөр зүйлд зарцуулж байгаа нь дэндүү хариуцлагагүй явдал юм,
- 4 жил тутам төрийн тахилга явагдаж байна, энэ хугацааг уртасгаж өгнө үү,
- Амлалт нэхэх ард түмний хөдөлгөөнийг юу гэж бодож байна, Оюу толгойн гэрээг зөв зүйтэй хийсэн талаар,
- Удахгүй сонгуулийн тухай хуулийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх гэж байгаа тул мөнгөний амлалтаас ангижруулах, олон шатны сонгуулийг давхцуулж өртөг зардалаа багасгах тал дээр анхаарч ажиллана уу,
- Парламентын 2 танхимтай болж, Ардын их хурлын гишүүдээс Бага хурлын гишүүдийг сонгодог тогтолцоо зөв зүйтэй санагдаж байна,
- Аймаг, орон нутгийн ИТХ-ийн эрх мэдлийг нэмэгдүүлэх хэрэгтэй,
- Хоёр намын амласан “Эх орны хишиг” болон “Эрдэний хувь” болох 1.5 сая, 1.0 сая төгрөгийг малчид, төрийн албан хаагчдын зээлд зориулж, ард иргэдээ зээлээс ангижруулмаар юм,
- Иргэний хөдөлгөөн УИХ, ЗГ-ыг огцруулна гэх юм, та нар огцрох уу? мөрийн хөтөлбөр өө хэр биелүүлж байна,
- УИХ-ын гишүүдийг элдвээр бичиж, хэлж байна – энд хариуцлага тооцдоггүй юм уу, УИХ-ын гишүүд тойргийн сум, суурин газраар ажилладаг, айл өрх, малчдын гэр, багийн төвд ажиллаж болдоггүй юм уу,
- Өргүй зарим малчид зээл авч, өвс тэжээл худалдан авч малдаа өгч байна, Хоёр намын амласан мөнгийг авч малдаа өвс, тэжээл бэлдмээр байна, хээл их хаяж байна, сүүлдээ эх малаа авч үлдэх гэж хичээж байна, жил ирэх тутам өвсний гарц муудаж байна,

- Хорт өвсний асуудал өдий хүртэл шийдэгдээгүй байна. Хорт өвсөнд мал, ялангуяа адуу их хордож, татаж унах, улмаар үхэж байна. Хорт өвсийг үндсээр нь зулгаагаад ч нэмэр алга, хот суурингаас мэргэжилтэнгүүд ирээд ч оновчтой устгах аргыг одоо хэр олоогүй л байна, энэ асуудлыг яах вэ,
- Ус татарч байна. Ховд гол 2 салаалан урсаж Хар ус нуурт цутгадаг байсан бол одоо 1 салаагаар урсан цутгаж байна,
- Төсвийн таналт их байна, нүүрсний үнэ өсч байна. Эндээс халаалтын төлөвлөгөө хугацаандаа хийгдэхгүй байна,
- Төсөв зохиох, батлах, гүйцэтгэл тооцох аргаа өөрчлөх хэрэгтэй. Учир нь одоо ашиглагдаж байгаа арга бол социализмын үеийн аргачлал,
- Хоёр нам сонгуульд их хэмжээний бэлэн мөнгө амлаагүй бол ард түмэн банкны зээлд хамрагдаж, өрөнд баригдахгүй байх байсан,
- Монголын үндэсний радио нэвтрүүлэгээр алсан талсан, хар бараан мэдээ их явагдаж байна, сэтгэл санаагаар дэмжсэн мэдээ явуулж өгнө үү.

зэрэг асуудлыг хөндөж, УИХ-ын гишүүн Р.Амаржаргал болон аймгийн ХЗБХ-ийн дарга Б.Алтанбадралт нараас мэдээлэл сонсож, санал солилцсон юм. Уулзалтад 100 гаруй иргэд оролцов.

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал өөрийн зардлаар Мянгад сумын Баянбулаг багаас төлөөлөл болгон 10 гаруй хүнийг өөрийн уулзалтад урьж оролцуулсан юм.

*Мянгад суманд хийсэн уулзалтын үеэр – 2010.03.17*



*Мянгад суманд хийсэн уулзалтын үеэр – 2010.03.17*

*Баянбулаг багийн төлөөлөгчидийг хүлээн авч уулзав - 2010.03.17*



## ЧАНДМАНЬ СУМ – 2010.03.17

*Чандмань сум руу явах зам зуур*



*Хар ус нуур дээгүүр*



*Цасанд суусан машин...*



*Жаргалант хайрхан*

Чандмань суманд товлосон цагаасаа хоцорч ирсэн тул шууд иргэдтэй хийх уулзалтаа эхлүүллээ. Уулзалтын эхэнд сумын эмнэлэг, сургууль, цэцэрлэг зэрэг төсөвт байгууллагын албан хаагчидын санал бодлыг сонссон юм.

Сумын хэмжээнд:

- Эмнэлэгийн ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, илүү цагийн мөнгө өгч чадахгүй байгаа байдлыг харгалзан үзэж 2010 онд 90 сая төгрөг шаардлагатай байгаагаас 10.1 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэж өгнө үү. Одоогийн байдлаар 2.0 сая орчим төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл дутуу, бензин шатахууны зардал хүрэлцэхгүй байгааг харгалзан үзэж шийдвэрлэж өгнө үү. Мөн хүн эмнэлэгийн чийрэгжүүлэлтийн танхим байгуулахад 3.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлнэ үү,
- Цаг уурын газар нь бэлчээрийн даацын мэдээг үнэн зөв гаргахад бензин шатахуун хүрэлцэхгүй байгааг харгалзан үзэж 150 000 төгрөгийн асуудлыг шийдвэрлэж өгнө үү. Мөн цаг уурын харуулын албаны ажлын хэрэгцээнд 1 ширхэг иж бүрэн компьютерийг шийдвэрлэж өгнө үү,
- 2011 онд сумын цэцэрлэгийг их засварт оруулж өгөх, тоног төхөөрөмж, сургалтын орчинг шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ үү,

- 12 жилийн сургуулийн номын санг өргөтгөн уншлагын танхим байгуулахад 4.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын асуудалд дэмжлэг үзүүлнэ үү,
  - Үүрэн телефоны Жи-Мобайль сүлжээнд холбогдох асуудлыг зохих газарт нь хандаж шийдвэрлэж өгнө үү,
  - Шинэр баригдсан Соёлын төв-Хөөмийн ордны аппаратур, хөгжим, техник тоног төхөөрөмж худалдан авахад 5.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын асуудалд дэмжлэг үзүүлнэ үү,
  - Олон жилийн дунджаас энэ жил илүү хүйтэн байсан тул төсөвт байгууллагын түлш, халаалтын зардал хэтэрсэн, өвөлжилт хүндэрсэн тул өвс тэжээлийн нөөц дууссан, эм хонь ихээр үхэж байна, малчид банкны зээлд (85% орчим) ихээр хамрагдсан.
- зэрэг асуудалд УИХ-ын гишүүн Р.Амаржаргалыг анхаарч ажиллан, дэмжлэг үзүүлэхийг хүссэн юм.



*Чандмань сумын уулзалтын үеэр – 2010.03.17*

Иргэд, сонгогчдоос:

- Шуудан банк – Зээлийн эргэн төлөлт, хугацаа хэтрэлт их байна. Зээлийн хугацааг сунгасан хэдий ч төлж чадахгүй болсон малчид байгаа. Хаан банкыг бодвол зээлийн багц багатай байна,
  - Хаан банк – Малчдад олгох ёстой зээлийн багцын дийлэнхи нь олгогдсон. 20-30 зээлийг шүүхэд шилжүүлсэн. Хугацаа хэтэрсэн зээл байгаа. Олгогдсон зээлүүд даатгалд хамрагдаагүй,
  - Сум, орон нутагт төсөв хүрэлцдэггүй байдлыг анхааралдаа авч ажиллана у,
  - 2021 хүртэлх сум хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 7.5 тэрбум төгрөг шаардлагатай байгаа,
  - Сумын Баянхайрхан баг нь 130 өрх, 564 хүнтэй. Малчид бүгд банкны зээлд хамрагдаж мал нь зудад нэрвэгдэж зээлээ эргэн төлөх боломжгүй болсон. Иймээс малчдыг ажлын байраар хангаж өгнө үү.
  - Хоёр нам сонгуульд их хэмжээний бэлэн мөнгө амлаагүй бол ард түмэн банкны зээлд хамрагдаж, өрөнд баригдахгүй байх байсан. Иймээс амласан мөнгө нэн даруй өгөх, эсбөгөөс банкны зээлээс чөлөөлөх асуудлыг анхааралдаа авна уу
- Бизнес Инкубатор төв байгуулахад дэмжлэг үзүүлсэнд сум, орон нутгийн удирдлага,

иргэдээс талархаж буйгаа илэрхийлмээр байна. Энэ ажлын хүрээнд 13 цех ажиллаж, 60 гаруй иргэд ажлын байраар хангагдах юм. зэрэг асуудлыг хөндөж, УИХ-ын гишүүн Р.Амаржаргал болон аймгийн ХЗБХ-ийн дарга Б.Алтанбадралт нараас мэдээлэл сонсож, санал солилцсон юм. Уулзалтад 120 гаруй иргэд оролцов.

Уулзалтын дараа УИХ-ын гишүүн сумын бизнес инкубатор төвийн барилгын ажлын үйл явцтай танилцаж, хөөмийн урлагийн гайхалтай хэсэгчилсэн тоглолтыг үзэж сонирхсон юм.



*Нутгийн залуу хүргэж өгөв*



*Бизнес инкубатор төвийн барилгын үйл явц*



*Бизнес инкубатор төвийн барилгын үйл явц*



*Хөөмийн урлагийн гайхалтай тоглолт*

### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ УУЛЗАВ – 2008.03.18

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал Аймгийн Засаг дарга Г.Нямдаваа нар:

- Малжуулах төсөл
- Бэлчээр ашиглалт
- Мөст, Мянгад, Эрдэнэбүрэн сумдын хүн эмнэлэгийн тэрэгний асуудал
- Баруун замын тендерийн ажлын нөхцөл байдал
- Цэвэр бохир усны цэвэрлэх байгууламжийн төсөл

зэрэг асуудлуудын хүрээнд санал солилцов. Мөн төрийн бодлогын түвшинд тулгамдаж буй ямар асуудал байгаа талаар Г.Нямдаваа даргын саналыг сонссон юм.

--- о О о ---